



ВИДЕО КОНТЕНТ, ПОДКАСТ
БҮТЭЭГЧ КОМПАНИУДАД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.08.26 № 3-3/1176

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Манай төвөөс оношлогооны сүлжээг оновчтой болгох (DNO) төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн иргэдийг ХДХВ-ийн халдвар илруулэх сэдэвт мэдээлэл сурталчилгааны видео контент бүтээлгэхээр төлөвлөж байна. Эрүүл мэндийн боловсрол, нийгмийн эерэг хандлагыг дэмжсэн **видео контент** бүтээгч байгууллагуудыг хамтран ажиллахыг урьж байна. Энэхүү үйл ажиллагааг 18,000,000 (арван найман сая) төгрөгийн төсөвт өртгөөр хийлгэх тул видео контент бүтээгч компаниуд үнийн саналаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтын дагуу 2026 оны 09 дүгээр сарын 07-ны дотор ирүүлнэ үү.

Саналыг байгууллагын албан тоотоор баталгаажуулж холбогдох материалын бүрдэл (улсын бүртгэлийн гэрчилгээ, ижил төстэй ажлын гэрээ, мэдээлэл)-ийг ханган tender@nccd.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ



С.ЭНХБОЛД

Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн ерөнхий захирлын 2026 оны
2-2/1196 дугаартай албан бичгийн хавсралт



D2H төслийн хүрээнд “ХДХВ-ийн шинжилгээнд хамрагдахын
ач холбогдол” сэдэвт мэдээлэл сурталчилгааны
видео контент бүтээх ажлын даалгавар

№	Үйл ажиллагаа	Тоо хэмжээ	Тавигдах шаардлага
1	Орон нутгийн иргэдийг ХДХВ-ийн халдвар илруулэх шинжилгээнд хамрагдахын ач холбогдол сэдэвт мэдээлэл сурталчилгааны видео контент бүтээх	- 4 төрлийн богино хэмжээний видео	- Видео контент нь агуулга найруулгын алдаагүй, энгийн ойлгомжтой байх - Дуу, дүрсний өндөр чанартай (full HD/4K) тайлбар бичвэр (subtitle), анимейшн зэрэг мультимедиа элементийг багтаасан байх - Олон нийтийн цахим сүлжээн (TikTok, Facebook Reels, Instagram Reels, YouTube Shorts)-д ашиглах боломжтой байх
2	Бүрдүүлэх материал	- Үнийн санал - Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Ижил төстэй ажил (видео контент, медиа бүтээл, нэвтрүүлэг) гүйцэтгэж байсан ажлын гэрээ, бүтээлийн жишээ холбоос (2-оос доошгүй)	